



СЭЛЭНГЭ АЙМГИЙН
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН
ТЭРГҮҮЛЭГЧДИЙН ТОГТООЛ

2020 оны 01 сарын 15 өдөр

Дугаар 07

Сүхбаатар сум

2020 оны ойгоос бэлтгэх модны нэмэлт
хуваарь батлах тухай

Ойн тухай хуулийн 32 дугаар зүйлийн 32.2 дахь заалт, Байгаль орчин, аялал жуулчлалын сайдын 2019 оны “2020 онд ойгоос бэлтгэх модны дээд хязгаар батлах тухай” А/602 тоот тушаалыг үндэслэн ТОГТООХ нь:

1. Аймгийн нутаг дэвсгэрээс 2020 онд ойгоос нэмэлтээр бэлтгэх хэрэглээний модны хэмжээг хавсралтаар баталсугай.
2. Баталсан хязгаарт багтаан зөвшөөрөл олгож огтлолтын төрөлд нь тааруулан ойн мэргэжлийн байгууллагуудаар бэлтгүүлэн хяналт тавьж ажиллахыг сумдын иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, Засаг дарга нарт тус тус үүрэг болгосугай.
3. Ойгоос мод бэлтгэх ажлыг аж ахуйн нэгж байгууллага, ойн санг гэрээгээр эзэмшигч нөхөрлөлүүдээр холбогдох заавар журмын дагуу бэлтгүүлэн өөрийн хөрөнгөөр ойжуулах ажлыг гүйцэтгүүлэхийг аймгийн Байгаль орчин, аялал жуулчлалын газрын даргын үүрэг гүйцэтгэгч /З.Түвшинтөгс/-д үүрэг болгосугай.
4. Тогтоолын биелэлтэнд холбогдох хууль, тогтоомжийн дагуу хяналт тавьж ажиллахыг аймгийн Мэргэжлийн хяналтын газрын дарга /Ж.Отгонхүү/-д үүрэг болгосугай.



ДАРГА Г.БЯМБАА

Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн
Хурлын Тэргүүлэгчдийн 2020 оны 01
дүгээр сарын 15-ны өдрийн 07 дугаар
тогтоолын 01 дүгээр хэсвэрлэлт

"2020 ОНЫ ОЙГООС БЭЛТГЭХ МОДНЫ НЭМЭЛТ ХУВААРЬ БАТЛАХ ТУХАЙ"

№	Сумын нэр	Зориулалт	Модны төрөл	Хэмжих нэгж	Мод бэлтгэх арга, төрөл					Бүгд
					Үйлдвэрлэлийн ашиглалтын огтлолтоор	Арчилгааны огтлолтоор	Цэвэрлэгээний огтлолтоор	Уламжлалт бүтээгдэхүүн үйлдвэрлэх зорилгоор	Цэвэрлэгээний ажлаар	
1	Түшиг	хэрэглээ	нарс	м3	700	300				1000
		Дүн		м3	700	300	0	0	0	1000
		түлээ	нарс	м3	100	75				175
		Дүн		м3	100	75	0	0	0	175
		Нийт		м3	800	375	0	0	0	1175

Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн
Хурлын Тэргүүлэгчдийн 2020 оны
01 дүгээр сарын 15-ны өдрийн 07
дугаар тогтоолын 02 дугаар
хэсвэрэлт

"2020 ОНЫ ОЙГООС БЭЛТГЭХ МОДНЫ НЭМЭЛТ ХУВААРЬ БАТЛАХ ТУХАЙ"

№	Сумын нэр	Бэлтгэх сумын нэр	Үйлдвэрлэлийн огтлолт	Арчилгааны огтлолт	Цэвэрлэгээ		Уламжлалт бүтээгдэхүүн үйлдвэрлэх зорилгоор	Нийт хэрэглээ	Түлээ	Бүгд дүн
					Огтлолт	Ажил				
1	Түшиг	Өөрийн сумаас	700	300				1000	175	1175
	Нийт дүн		700	300	0	0	0	1000	175	1175

Байгаль орчин аялал жуулчлалын газар